



## ▶ Уул уурхайд КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэхэд ашиглах хяналтын шалгах хуудас

**Энэхүү шалгах хуудас нь КОВИД-19 цар тахал уул уурхайд тархахаас урьдчилан сэргийлэх, бууруулах, практик үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байнга сайжруулахад туслах зорилготой юм.**

### Шалгах хуудсыг хэрхэн хэрэглэх талаар:

- ▶ Өөр өөр чиг үүрэг бүхий, төрөл бүрийн ажил, мэргэжлийн цөөн хүний бүрэлдэхүүнтэй баг томилох;
- ▶ Багийн гишүүдийг шалгах хуудсыг хэрхэн ашиглах, бөглөх, хариултуудыг тэмдэглэх талаар мэдээлэл өгч, сургах;
- ▶ Баг дотроо ямар арга хэмжээг хэн хэрэгжүүлэх, “Үгүй” гэж тэмдэглэгдсэн асуултуудад хэзээ хариу арга хэмжээ авах талаар тохиролцох;
- ▶ Авах арга хэмжээний саналаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, дээд удирдлагад эсвэл арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх талаар удирдах зөвлөлд танилцуулах;
- ▶ Томилогдсон баг асууж тодруулах зүйлсээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн хяналтын байцаагч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийгэмлэг, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагуудаас лавлах.

### Анхаарах шаардлагатай зүйлс:

Энэхүү шалгах хуудсыг үр дүнтэйгээр хэрэглэхэд уурхайн удирдлага, ахлах ажилтнууд, ажилтан болон тэдний төлөөлөгчдийн идэвхитэй хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлээс хамаарна. Уурхайн удирдлагууд нийт ажилтнуудынхаа аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах үүрэгтэй бөгөөд уг үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, ажилтны төлөөллийг оролцуулах шаардлагатай. Ажилтнууд ажлын байранд мөрдөгдөх аливаа дүрэм, журмыг чанд мөрдөх, ажил үүргээ гүйцэтгэх явцад амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн бол ажлаа зогсоох эрхтэй байдаг.

Энэ шалгах хуудас нь шаардлагатай бүх арга хэмжээг нарийвчлан, бүрэн жагсаагаагүй гэдгийг анхаараарай. Асуултуудыг нэмж оруулж болох бөгөөд уурхайн өөрийн онцлог, өвөрмөц байдал болон үндэсний хууль тогтоомж, КОВИД-19 өвчний халдварын эсрэг хариу арга хэмжээг сайжруулах зөвлөмжийг харгалзан үзнэ.

Уурхайн удирдлагууд Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, үндэсний хууль тогтоомжийг биелүүлэх үүрэгтэй. Зөвлөмжүүдийг *FAQ (Түгээмэл асуултын хариулт)-аас КОВИД-19 өвчний халдвар тархсантай холбоотойгоор олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний гол зохицуулалт болон Уул уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 1995 оны 176 дугаар конвенц, 1995 оны 183 дугаар зөвлөмж, Нүүрсний гүний уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны ОУХБ-ын практик удирдамж мөн Ил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ОУХБ-ын практик удирдамж, Ажилтны эрүүл мэндэд хяналт тавих техник, ёс зүйн удирдамжийг үзэж болно.*

## ► 1. Нөөц болон удирдлагын системийг төлөвлөх

1.1	Уурхайн удирдлагаас КОВИД-19 цар тахлын тархалт, түүний халдвараас хамгаалах, бууруулах бодлого, чиглэлээ боловсруулж, ажилтан, тэдгээрийн төлөөлөгчидтэй зөвлөлдөж, танилцуулсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	Уурхайд КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих бэлэн байдлын болон хариу арга хэмжээний төлөвлөгөөг дангаар эсвэл менежментийн бусад төлөвлөгөөний хэсэг болгон ажилтнууд, тэдгээрийн төлөөлөгчтэй зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулж, түршсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлтийн статус, гэрээний хэлбэрээс үл хамаарч бүхий л ажлын байр, чиг үүргийг хамарч чадсан уу?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.2	<ul style="list-style-type: none"> <li>Халдвар тархах боломжит бүх эх үүсвэр, хүчин зүйлс (уурхайн бохирдуулагч эх үүсвэр; мөн уурхайн ажилтнууд хоорондоо эсвэл гэрээлэгчид, ханган нийлүүлэгч, хэрэглэгч, зочид, уурхай байрлах нутгийн иргэдтэй харилцах гэх мэт)?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Төлөвлөгөөг олон улсын хэм хэмжээ, удирдамж чиглэлтэй нийцүүлсэн эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Төлөвлөгөөг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, дээд удирдлага эсвэл удирдлагын зөвлөлөөс баталсан уу?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.3	КОВИД-19 өвчний халдвартай холбогдуулан эрсдэлийн үнэлгээг ажилтан, тэдгээрийн төлөөлөгчидтэй хамтран тусгайлан хийж, илэрсэн эрсдэлийг арилгах талаар бэлэн байдлын болон хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих бэлэн байдлын болон хариу арга хэмжээний төлөвлөгөөнд хөрөнгө төсөвлөсөн эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Ажиллагчдын тоотой уялдуулсан нөөц хуваарилж, эрсдэлийн эсрэг авах хариу арга хэмжээг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад хэт ачаалал үүсгэхгүйгээр зохион байгуулж чадах эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Саван, халдваргүйжүүлэгч, гар ариутгагч, цаасан алчуур, цаасан сальфетикийн нөөц хангалттай эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.4	<ul style="list-style-type: none"> <li>КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх эмэгтэй, эрэгтэй ажилтнуудын нүүрний маск, халхавч, бээлий, нүдний шил зэрэг болон бусад хувийн хамгаалах хэрэгслийн нөөц хангалттай эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Ажилтан, гэрээлэгч, ханган нийлүүлэгчдийн биеийн халуун алсаас хэмжигч хангалттай эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Шинжилгээ хийх боломжтой бол ажлын байрандаа ажилтнуудад шинжилгээ хийх боломжтой эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>Урьдчилан хянах, тусгаарлах, хөл хорио тогтоох хэсгийг байгуулж, ашиглахад бэлэн байгаа эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.5	КОВИД-19 өвчний халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл бүрдүүлж, ажилтныг ойролцоох эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад байгууллагын зардлаар аюулгүй шилжүүлэх зохицуулалт хийсэн эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

1.6	Хариу арга хэмжээний баг, түүнийг удирдах үүрэг бүхий хүнд КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг ногдуулсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Хариу арга хэмжээний баг, удирдах хүн нь халдварт өвчний талаар сургагдсан эсэх, мөн бэлэн байдал, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх туршлагатай эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Байгууллагын эрүүл мэндийн ажилтан, нийгмийн ажилтан, зөвлөх, хамгаалалтын ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер, албан хаагчид, аюулгүй байдлын эрүүл мэндийн зөвлөл, төлөөлөгчид, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх бусад гол ажилтнууд КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, хянах талаар сургагдсан эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер бэлэн байдал, хариу арга хэмжээ зохион байгуулах багт багтаж байгаа эсвэл төлөвлөгөөг хариуцаж байгаа ажилтантай үйл ажиллагаагаа үялдуулж байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Дээр дурьдсан гол ажилтнууд КОВИД-19 өвчний халдварын шинжилгээ хийлгэж, өдөр тутам хянагдаж байгаа эсэх? <sup>1</sup>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.7	КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг идэвхитэй хэрэгжүүлж, хяналт тавьж, байнга сайжруулж байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.8	Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээний эрүүл мэндийн байгууллагуудтай КОВИД-19 өвчний халдварын талаар сүүлийн үеийн чиглэл, зөвлөмж тогтмол авч, бэлэн байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөндөө тусгасан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.9	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, гарч байгаа асуудлыг сайжруулах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, дээд удирдлага эсвэл удирдлагын зөвлөлд танилцуулсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

## ► 2. Сургалт ба харилцан мэдээлэл солилцох

2.1	Уурхайн удирдлага, ажилтнууд, тэдгээрийн төлөөлөгчид вирусын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, КОВИД-19 өвчний халдвар гарсан тохиолдолд хэрхэн ажиллах талаар мэдээлэл авч, сургалтанд хамрагдсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Ажил мэргэжил, чиг үүргийн онцлог эрсдэлд үндэслэсэн байдлаар сургалт хийсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Сургалтаар хувийн хамгаалах хэрэгслийг хэрхэн зөв хэрэглэхийг заасан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Сургалтыг системтэй, цагаа олсон, зан заншилд нийцсэн, тогтмол байдлаар, үндэсний хэлээр хийсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

<sup>1</sup> For testing and workers' health surveillance, please refer to the ILO Technical and ethical guidelines for workers' health surveillance as well as to national health authorities and laws for guidance.

2.2	<p>Ажилтнууд, гэрээлэгчид, ханган нийлүүлэгчдийг уурхай болон уурхайн ойролцоо суурин газруудад КОВИД-19 халдвар тархахаас хэрхэн сэргийлэх талаар хамгийн сүүлийн үеийн, бодит мэдээллээр хангах системийг бий болгосон эсэх?</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэдээллийг ДЭМБ болон үндэсний, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан сүүлийн үеийн мэдээлэл, зөвлөмжид үндэслэж гаргадаг эсэх?</li> <li>• Мэдээллийг постер, тэмдэглэгээ хэлбэрээр үндэсний хэлээр, соёл, зан заншилд нийцсэн байдлаар илэрхийлсэн үү?</li> <li>• Эрүүл мэнд, эрүүл ахуй, хяналтын бусад мэдээллийг ажилтан, гэрээлэгч, ханган нийлүүлэгчдэд зориулсан танилцуулах (induction) сургалтад багтаасан үү?</li> <li>• Нотолгоонд суурилсан эрүүл мэнд, эрүүл ахуйн практик мэдээллийг одоо байгаа заавал болон сайн дурын сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулах төрөл бүрийн хэлбэр (компьютерт суурилсан сургалтын хөтөлбөр эсвэл цаасан хэлбэр, сонин сэтгүүл емейл гэх мэт)-ээр явуулдаг эсэх?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.3	<p>Уурхайн удирдлагаас гэрээлэгч, ханган нийлүүлэгч, ажилтан, тэдгээрийн төлөөлөгчдөд цаг үеийн чухал асуудлаар ХАБЭА-н сургалт, ажил эхлэхийн өмнө зааварчилгаа зэргийг боломжтой бол цахим хэлбэрээр эсхүл хүн хоорондын зайг баримтлан зохион байгуулдаг үү?</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургалт, мэдээлэлд КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих тухайлбал, хүн хоорондын зай барих, биечлэн хүрэлцэх болон бусдын эд зүйлсийг хэрэглэхээс зайлсхийх, хувийн ариун цэвэр сахих (гараа савангаар байнга угаах, спиртэн суурьтай ариутгагч хэрэглэх, нүүрэндээ гараа хүргэхгүй байх гэх мэт), ханиаж найтаах үедээ цаасан алчуур эсвэл гарын шууны дотор талыг ашиглах, ажлын байрны ариун цэврийг сахих (ажлын байранд ашигладаг багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, өргүүр, шахуурга, бараа материал, уурхайн лифт, хонгил, бие засах газрын суултуур, орц, гарцны төхөөрөмж, шатны бариул, ширээ сандал гэх мэт) зэрэг арга хэмжээг багтаасан үү?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.4	<p>Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн бол уурхайн аль ч байрлалд ажлаа зогсоох эрхтэй байдаг талаар ажилтнуудад мэдээлэл өгсөн үү?</p>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.5	<p>Уурхайд болон ойролцоох суурин газрын оршин суугчдад КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг хянах арга хэмжээ, нөхцөл байдлын талаар мэдээлэл өгч, зөвлөлдсөн үү?</p>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.6	<p>Ажилтнууд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд уурхайн газарт (сайт) сэтгэл зүйн болон зөвлөгөө өгөх үйлчилгээ, туслалцаа үзүүлэх хөтөлбөр (сэтгэцийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн анхан шатны)-т хамрагдах, уурхайн кампуст (24/7 дуудлагын төвөөр үйлчлүүлэх гэх мэт) талаар мэдээлэл өгсөн үү ?</p>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

### ► 3. Ажилтны эрүүл мэндэд хяналт тавих, өөрийгөө хянах, хавьтлуудыг илрүүлэх

3.1	<p>КОВИД-19 өвчний халдварын хяналтын нууцлал бүхий системийг үндэсний хууль тогтоомжтой нийцүүлэн ажилтан тэдгээрийн төлөөлөлтэй хамтран бий болгосон эсвэл ажилтны эрүүл мэндийг хянах системийн нэг хэсэг болгосон үү?</p> <ul style="list-style-type: none"> <li>Уурхайн удирдлагаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйлчилгээний байгууллага, эрүүл мэндийн орон нутаг, бүс, үндэсний байгууллагатай холбогдон ажилтнуудыг КОВИД-19 өвчний халдварын шинжилгээнд уурхай, кампуст үнэгүй хамрагдах боломжоор хангагдсан үү?</li> <li>Өндөр эрсдэл бүхий эмзэг бүлгийн жагсаалтыг бий болгосон үү?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй  <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй  <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй  <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй  <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3.2	<p>Ажилтнуудад өөрийн эрүүл мэндээ хэрхэн хянаж, нийтлэг шинж тэмдэг (халуурах, хуурай ханиалгах, ядрах зэрэг) илэрсэн тохиолдолд мэдээлэх талаар зөвлөгөө өгсөн үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3.3	<p>Ажилтнуудад ямар нөхцөлд өөрийгөө тусгаарлах, яаралтай үед авах арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3.4	<p>Уурхайд ажилтан, гэрээлэгч, ханган нийлүүлэгч, зочид нэвтрэх үед хяналтын арга хэмжээ (биеийн халуун хэмжих, эрүүл мэндийн асуулга бөглүүлэх гэх мэт)-г хэрэгжүүлдэг үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3.5	<p>Халдварын шинж тэмдэг илэрсэн ажилтныг тусгаарлах зориулалт бүхий өрөөг бэлтгэж, ашиглах журмыг гаргасан үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3.6	<p>КОВИД-19 өвчний халдвар авсан байх магадлалтай, эсвэл халдвар авсан нь батлагдсан хүнийг тодорхойлох, хавьтлыг илрүүлэх систем, журам бий болгосон үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3.7	<p>КОВИД-19 өвчний халдварын тохиолдол, шинж тэмдэг бүртгэгдсэн тохиолдолд уурхайн удирдлага, хамтран ажиллагчид, ХАБЭА-н зөвлөл, хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага, орон нутаг, бүс, үндэсний эрүүл мэндийн байгууллагад мэдээлдэг үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

### ► 4. Эрүүл ахуй, ариутгал цэвэрлэгээ

4.1	<p>Уурхайн удирдлагаас ажилтны төлөөлөгчидтэй зөвлөлдсөний үндсэн дээр үйлдвэрлэлийн эрүүл ахуйн сайн түршлага (ажлын тоног төхөөрөмжийг ялангуяа ээлж солигдох үед ажлын байр түүний орчныг тогтмол ариутгах зэрэг) нэвтрүүлсэн үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
4.2	<p>Уурхайн удирдлагаас ажилтны төлөөлөгчидтэй зөвлөлдсөний үндсэн дээр ажилтны хувийн эрүүл ахуйн сайн түршлагыг дэмжиж (ханиаж найтаах үедээ цаасан алчуур эсвэл гарын шууны дотор талыг ашиглах), гараа тогтмол угаах, ажлын тавцан, багаж тоног төхөөрөмжүүдийг халдваргүйжүүлэгч бодисоор арчиж цэвэрлэдэг үү?</p>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

4.3	Хувийн ариун цэвэр сахих, гараа зөв угаах талаар сурталчилгааны хуудсыг байрлуулсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.4	Ажилтнууд, гэрээлэгч, ханган нийлүүлэгч, зочдыг гараа саван, усаар угаах, спиртэн суурьтай ариутгагчаар гараа ариутгах боломжоор хангасан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.5	Спиртэн суурьтай ариутгагчийг уурхайн газарт (сайтад) хангалттай хэмжээгээр байршуулж, тогтмол дүүргэдэг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.6	Зохих шаардлага хангасан нүүрний маскаар хангаж, хэрэглэсэн цаасан алчуурыг тагтай хогийн саванд хийж, устгадаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.7	Уурхайн ажлын байр, бүх хэсгийг тусгайлан томилогдсон ажилтнууд цэвэрлэгээний бодисоор цэвэрлэж, багаж, машин тоног төхөөрөмж, хяналтын товчлуур, өргүүр, хоолой, эд материал, уурхайн лифт, хонгил, бие засах газрын суултуур, орц, гарцийн төхөөрөмж, шатны болон хаалганы бариул, ширээ сандал, утас, радио, машин, ажлын тавцан, хурал, нийтийн зориулалттай өрөө, компьютерийн гар, дэлгэц, хана, шал, угаалгын өрөө, хоолны газар, цайны өрөө, хувцасны шүүгээ, нийтийн шүршүүр зэрэг зүйлсийн ариутгал, цэвэрлэгээнд онцгой анхаардаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.8	Гал тогоо болон нийтийн хоолны тоног төхөөрөмж, хоолны хэрэгсэл, халбага, сэрээ, аяга таваг, автомат машин, ус цэвэршүүлэгч, стакан зэргийн ариутгал, цэвэрлэгээнд онцгой анхаардаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.9	Байнга ашигладаг болон байнга хүрэлцдэг гадаргуу, дээр дурьдсан тоног төхөөрөмжийг цэвэрлэж, ялангуяа ээлж солих үед тогтмол ариутгадаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.10	Гадуур хувцас, гутал, бээлий, малгай, нүдний шил, амьсгалын аппарат зэрэг ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг цэвэрлэх, ариутгах тусгай журам мөрддөг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

## ► 5. Уурхайн газарт (сайтад) нэвтрэх болон хөдөлмөр зохион байгуулалт

5.1	Уурхайн сайтад шаардлагагүйгээр нэвтрэх байдлыг хамгийн бага болгож хязгаарласан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Уурхайн удирдлагаас нэвтэрч байгаа бүх хүмүүст зөвшөөрөл олгож, гэрээт ажил, хүргэлтэд хяналт тавьдаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Төлөвлөгөөгүйгээр ирж байгаа ажилтан, ханган нийлүүлэгч, зочдын нэвтрэхийг хязгаарладаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Ажилтнуудын уурхайн сайт руу нэвтрэх, гарах үрсгал хөдөлгөөнийг хамгийн бага болгож хязгаарлаж чадсан үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

5.2	<p>Уурхайн сайтад ажиллах ажилтны тоог бууруулах арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн үү?</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зайлшгүй шаардлагатай бус ажлыг багасгасан үү?</li> <li>• Гэрээсээ, цахимаар, өөр газраас ажиллах хэлбэрийг дэмжиж байгаа юу?</li> <li>• Илүү цагаар ажиллах, яаралтай дуудаж ажиллуулах байдлыг хамгийн бага болгож хязгаарласан үү?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
5.3	<p>Олон тооны ажилтнууд нэг дор бөөгнөрөхөөс зайлсхийж, хүн хоорондын зай барих практикийг нэвтрүүлсэн үү?</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажил үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, завсарлага, хурал уулзалтыг төлөвлөж, уурхайн сайтын тодорхой хэсгүүд дээр ажилтнуудын бөөгнөрлийг бууруулсан үү?</li> <li>• Ээлжийн зохион байгуулалт, хуваарилалт хийснээр нэг газарт ажилтнууд олноор бөөгнөрөхөөс сэргийлж байгаа юу?</li> <li>• Ажилтнууд бие биетэйгээ ойрхон зөрөх, бөөгнөрөхөөс зайлсхийж, явган хүний хөдөлгөөнд хяналт тавих арга хэмжээ авсан үү?</li> <li>• Онлайн хэлбэрийг ашиглан хурал уулзалт зохион байгуулах, биечлэн уулзалт зохион байгуулах шаардлагатай бол хүн хоорондын зайг баримтлан гадаа эсвэл хангалттай зай талбайтай газар зохион байгуулдаг үү?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
5.4	<p>Ажлын төлөвлөгөө гаргахдаа эрсдэлтэй бүлгийн ажиллагсад (65-аас дээш настай, эрүүл мэндийн хувьд архаг, суурь өвчтэй гэх мэт)-ыг анхаарч, гэрээсээ ажиллах зэргээр зохицуулалт хийсэн үү?</p>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
5.5	<p>Ажлын зохион байгуулалтыг аль болох эрсдэлийг бууруулах (нэг ээлжинд гардаг ажилтнуудыг хамтад нь гаргах, ажилтнууд солигдох бол баг болгож тусгаарлах гэх мэт) байдлаар хийж байгаа юу?</p>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
5.6	<p>Хүн хоорондын зай барих арга хэмжээг хэрэгжүүлж, хянаж байгаа юу?</p> <ul style="list-style-type: none"> <li>• Орох, гарах хаалганд</li> <li>• Коридор, цахилгаан шатанд</li> <li>• Хүлээлгийн өрөө, уурхайн сайт руу хүргэх тээврийн хэрэгсэл хүлээхэд</li> <li>• Автобус, бусад тээврийн хэрэгсэлд</li> <li>• Уурхайн лифт, хонгилд</li> <li>• Уурхайн сайтад ашиглаж байгаа бүхээг, тээврийн хэрэгсэлд</li> <li>• Уурхайн сайтад цугларалт, хурал зохион байгуулахад</li> <li>• Уулзалтын өрөө, ажлын өрөөнд</li> <li>• Хоолны газар, хүнсний мухлагт</li> <li>• Ариун цэврийн өрөө, хувцасны шүүгээний хэсэгт</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

5.7	Ажилтнууд ямар нэгэн сэжигтэй тохиолдлыг ашиглаж байсан болон шинээр бий болгосон шүүрхай дугаарт мэдээлэхийг дэмждэг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
5.8	Өвчний чөлөө, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах, хүүхэд асрах чөлөөг үндэсний хууль тогтоомжтой нийцүүлэн сунгах талаар ажилтнууд мэдээлэлтэй юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

## ► 6. Тээвэр, хөдөлгөөний зохицуулалт

6.1	Уурхай, тээврийн ажилтнууд, бусад зорчигчдын эрсдэлийг хамгийн бага байлгах аргаар тээвэр хөдөлгөөнийг зохион байгуулж байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6.2	Уурхайн удирдлагуудаас нийт ажилтнуудад хандаж тээвэрлэлт, хөдөлгөөнийг хязгаарлаж, зайлшгүй нөхцөлд тээврийн хөдөлгөөн хийнэ гэдгийг анхааруулсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6.3	Ажил үүрэгтэй холбоотой аливаа тээвэрлэлт хийхдээ КОВИД-19 өвчний халдварын эрсдлийг тооцож, шийдэх өөр арга замыг авч үздэг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6.4	Уурхайн удирдлага нийгмийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран томиллоор зорчих ажилтнуудыг халдварын шинжилгээнд урьдчилан хамруулж, халдвартай эсвэл халдварын шинж тэмдэгтэй ажилтнуудыг өөр орон нутагт зорчих эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авдаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6.5	Уурхайн сайт рүү зорчихын өмнө ажилтнуудаас өмнөх 7 хоногт (буюу үндэсний байгууллагаас тогтоосон хугацаанд) эрүүл мэндийн хувьд ямар нэгэн зовиур, өндөр эрсдэлтэй байдалд (халдвартай хүнтэй уулзсан) орсон эсэхийг асууж, бие тавгүйтсэн, халдвартай, халдварын сэжигтэй хүнтэй хамт амьдардаг бол уурхайн удирдлагад мэдэгддэг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	Ажилтнуудыг уртын ээлж (ростер)-ээр агаарын нислэгээр тээвэрлэн ажиллуулахад үүсэх эрсдэлийг бууруулсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	<ul style="list-style-type: none"> <li>• Ажилтнуудыг тээвэрлэх давтамжийг бууруулах зорилгоор нэг ээлжийн ажиллах хоногийг уртасгах, ирж байгаа болон буцах ээлжийн хооронд зай гаргах (ядрах зэрэг бусад асуудлыг анхаарах) арга хэмжээ авсан уу?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6.6	<ul style="list-style-type: none"> <li>• Уурхайн удирдлагууд агаарын тээврийн компанитай зөвхөн гэрээт нислэгээр ажилтнуудаа тээвэрлэх, дунд хугацаанд чартер нислэгийг нэмэгдүүлэх тохиролцоо хийж байгаа юу?</li> <li>• Уурхайн удирдлага агаарын тээврийн компанитай хамтран эрүүл мэндийн зөвлөмжийн дагуу бүх нислэгт хүн хоорондын зай, эрүүл ахуйн дэглэм баримтлах арга хэмжээ авсан үү?</li> <li>• Нислэгийн үеийн аюулгүй байдлын зааварчилгаанд вирусээс сэргийлэх, эрүүл ахуйн дэглэмийн талаар нэмж оруулсан үү?</li> </ul>	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй



6.7	Авто тээврийн хэрэгслээр ажилтнуудаа ойролцоох суурин, кампаас тээвэрлэх үеийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Автобусанд суухын өмнө зорчигчдын биеийн байдлыг хянах механизм нэвтрүүлсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Уурхайн удирдлагууд нийтийн тээврийн үйлчилгээний компанитай зөвхөн гэрээт тээврийн хэрэгслээр ажилтнуудаа тээвэрлэх, дунд хугацаанд хувийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх тохиролцоо хийж байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Уурхайн удирдлага газрын тээврийн компанитай хамтран эрүүл мэндийн зөвлөмжийн дагуу бүх хүн хоорондын зай, эрүүл ахуйн дэглэм баримтлах арга хэмжээ авсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6.8	Уурхайн ойролцоо амьдардаг ажилтнууд хувийн тээврийн хэрэгслээр сайт дээр ирэх, байгууллагын тээврийн хэрэгслээр зорчихгүй байх түр арга хэмжээ авсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

## ► 7. Байрлуулах

7.1	Ажилтнуудын ихэнхи нь хаалттай кампус, хотхонд байрладаг уу, зочид буудал, хувийн байшинд байрлах ажилтнуудын тоог багасгасан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7.2	“Ор хуваалцах” буюу өөр ээлжийн ажилтнууд нэг өрөөнд зөрж байрлах практикийг аль болох багасгасан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7.3	Кампус, хотхоныг тухайлан бэлтгэгдсэн ажилтнууд үндэсний стандарт, КОВИД-19 өвчний халдвараас сэргийлэх зааварчилгааны дагуу ариутгаж цэвэрлэдэг үү ?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7.4	Кампус дотор, хооллох болон бусад байршлуудад хүмүүсийн бүхий л хөдөлгөөнийг багасгах арга хэмжээ авсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7.5	Кампус дотор (амрах, хоолны танхимд суух, хоол хүргэх үйлчилгээтэй холбоотойгоор) хүн хоорондын зай баримталж байгаа эсэхэд байнга хяналт тавьдаг үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7.6	Ажилтнууд ажлын бус чөлөөт цагаа хаана, хэрхэн өнгөрөөх, ингэхдээ хүн хоорондын зай, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх, уурхайн удирдлагаас ажилтнууд хоорондоо аюулгүй байдлаар харилцах талаар авч байгаа арга хэмжээг мэдээлсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7.7	Өндөр эрсдэлтэй бүлгийн хүмүүсийг бусадтай харилцахад хязгаарлалт тогтоосон уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

## ► 8. Ханган нийлүүлэгчид ба гэрээлэгчид

8.1	КОВИД-19 өвчний халдвараас сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд бүх төрлийн ханган нийлүүлэгчид, гэрээлэгчидтэй харилцах талаар тусгаж, ингэснээр гэрээний төрлөөс үл хамааран бүх ажилтнууд уг төлөвлөгөөнд хамрагдсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
8.2	Голлох ханган нийлүүлэгч, гэрээлэгчдэд сайт дээр ажиллаж байгаа бусад ажилтны нэгэн адил шаардлага (эрүүл мэндийн шинжилгээ, хянах хуудас бөглөх гэх мэт) тавьдаг уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
8.3	Ханган нийлүүлэгч, гэрээлэгчдэд тэдний эрүүл мэнд, эрүүл ахуйн практик, хяналтад уурхайн удирдлага урьдчилан анхаарч арга хэмжээ авч байна уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
8.4	Голлох ханган нийлүүлэгч, гэрээлэгчидтэй шууд харилцах холбоо тогтоосноор ажлын төлөвлөгөө өөрчлөгдөх, хяналтын арга хэмжээг хялбар байдлаар харилцаж, хэрэгжүүлэх боломж бүрдүүлсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
8.5	Хүргэлтийн ажилтнууд, ачааны машины жолооч, тээвэрлэлтийн бусад ажилтнууд ачаа шилжүүлэх цэг дээр ажилтнуудтай шууд харилцахгүй байх, хувийн ариун цэвэр (гараа угаах, ариутгах гэх мэт) сахиулах арга хэмжээ авсан үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
8.6	Бараа материал хүлээн авч байгаа ажилтнууд эд зүйлс, баглаа боодолтой харилцахдаа эрсдэлийг бууруулах, хянах талаар сургагдсан уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

## ► 9. Уурхай байрлах орон нутгийн иргэд

9.1	Уурхайн удирдлагууд уурхайн ойролцоо байрлах орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд КОВИД-19 халдвар хэрхэн нөлөөлөх, тэдэнд хаана, хэрхэн дэмжлэг үзүүлж болохыг тодорхойлсон үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• КОВИД-19 өвчний халдвар, нас баралт бүүрч байгааг тоо мэдээлэл харуулж байна үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Олон нийтэд чиглэгдсэн урьдчилан сэргийлэх кампанит ажил, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• КОВИД-19 өвчний халдварын шинжилгээ хийх боломжтой эсэх, хийгдэж байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага хангалттай нөөц бүрдүүлсэн эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• Ядуурал, ажилгүйдлийн түвшинд сөргөөр нөлөөлж байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	• КОВИД-19 өвчний халдварын эрсдэлээс шалтгаалан орон нутагт ямар нэгэн зөрчил үүсч байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

9.2	Уурхайн удирдлага орон нутаг, бүсийн эрүүл мэндийн байгууллагатай харилцах суваг бий болгож, цар тахлын хариу арга хэмжээ (халдварын тохиолдлыг мэдээлэх, шинжилгээ, хавьтлыг тогтоох үйл ажиллагаагаа уялдуулах, үндэсний хэмжээнд баримталж байгаа эрүүл мэндийн протоколын дагуу ажиллах) авдаг уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9.3	Орон нутгийн иргэдэд КОВИД-19 өвчний халдвараас сэргийлэх талаар уурхайгаас явуулж байгаа арга хэмжээ, мэдээллийг үндэсний хэл, ёс заншилд нийцсэн хэлбэрээр хүргэж байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9.4	Орон нутгийн эдийн засаг, иргэдийн эрүүл мэндийг дэмжсэн үйл ажиллагааг тухайн нутгийн иргэдийн оролцоотойгоор явуулж, эрсдэл өндөр бүлгийн иргэдийг хамгаалах зохицуулалт хийсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9.5	Орон нутгийн иргэд нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудыг халдвараас хамгаалах эрүүл ахуйн хатуу дэглэм мөрдүүлж байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9.6	Уурхайн сайтад ажилладаг нутгийн иргэдийг КОВИД-19 өвчний халдварын тархалтаас хамгаалах зохицуулалт хийсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9.7	Орон нутгийн иргэд, эрүүл мэндийн үйлчилгээг дэмжихэд зориулан сан бий болгох талаар анхаарч байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9.8	Орон нутгийн иргэд, холбогдох бусад хүмүүс нэмэлт мэдээлэл авах, хариу мэдээлэх механизм байгаа эсэх эсвэл ийм механизмыг шинээр бий болгосон эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9.9	Иргэд КОВИД-19 өвчинтэй холбоотой асуудлаар уурхайн сайттай холбоо барьж, шуурхай холбогдох (утсаар холбогдох гэх мэт) боломжтой юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

Хаяг:

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага  
4 Route des Morillons 4  
CH-1211 Женев 22, Швейцар

Салбарын бодлогын газар  
И: covidresponsesector@ilo.org